



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/5/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг
2020 он

| | | | |
|--------------------|---------------|-------------|---------------------------|
| Тэргүүлэх аудитор: | Д.Анхбаяр | Цахим хаяг: | |
| Утас: | 90900910 | Цахим хаяг: | |
| Аудитын менежер: | Ж.Энхцоодол | Цахим хаяг: | |
| Утас: | 99057478 | Цахим хаяг: | |
| Аудитор: | Г.Намчинсүрэн | Цахим хаяг: | Namchinsuren999@gmail.com |
| Утас: | 91995689 | Цахим хаяг: | Namchinsuren999@gmail.com |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | | |
|-------|---|-------------------------------------|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 4 |
| 2.1 | Оршил | 4 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 7 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 9 |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал | 10 |
| 2.9 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 10 |
| 2.10 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | Error! Bookmark not defined. |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл | 10 |
| 2.12 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.13 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 10 |
| 3 | Менежментийн захидал | 12 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 14 |

1 Аудитын гэрчилгээ

Батлагдсан гэрчилгээ скайннердаж энд оруулах

2 Аудитын тайлан

2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ү.Бямбасүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газрын Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв. Булган аймгийн газрын харилцаа барилга, хот байгуулалтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Газрын харилцаа барилгын салбарын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж газрын шимтгэлийн бодлогыг эрчимжүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, БХ Төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн мэдээллийн технологит түшиглэн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй шуурхай үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хуулийг дээдэлж хуулийн хүрээнд ажиллах
- Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байж салбарын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх
- Барилгын хяналтыг хэрэгжүүлэх
- Газрын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх

Тус байгууллагын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “эколоус” программ хангамж ашигладаг байна.

дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 27 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 292993.0 мянган төгрөгөөс тооцон 5859.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 662563.7 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 13251.3 мянган төгрөгөөр тооцсон нь байгууллагын нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг байдлын түвшин өндөр гарч байгаатай холбоотой болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган аймгийн газрын харилцаа барилга, хот байгуулалтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3256103.3 мянган төгрөгөөр буюу 0.57 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---------------------|--------------------|-------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 41451217.56 | 48294398.56 | 7143181.0 |
| Үндсэн хөрөнгө | 523673817.07 | 513274532.15 | -10399284.92 |
| Нийт хөрөнгө | 564825034.63 | 561568930.7 | -3256103.3 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | | | |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | | | |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд худалдан авсан, мөн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан бараа материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ. Бараа материалын дансанд 48294.8 мянган төгрөгийн материалын үлдэгдэл байгаа нь оны эцэст зайлшгүй хэрэгцээтэй 5600.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.

Тусгай зориулалтын Бараа материалын дансанд 2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 1426.3 мянган төгрөгийн хөрөнгийг газрын даамлуудад олгох шалтгаанаас шилжүүлээгүй бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө оруулалтаар 19130.0 мянган төгрөг, худалдан авалтаар 21271.6, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн нийт 40401.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн ч 26774.4 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 561568.9 мянган төгрөг болж 3256.9 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын өсөлт, үндсэн хөрөнгийн асалт, бууралтаас шалтгаалсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй болно.

2.09. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар тайлант онд 56500,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 88178.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 156.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------------------------------|----------------|----------------|----------------|--------------|
| Барилгын техник хяналт | 40000.0 | 67276.8 | 27276.8 | 168 |
| Газрын кадастр, үнэт цаасны орлого | 16500.0 | 20901.5 | 4401.5 | 126.6 |
| | | | | |
| Нийт дүн | 56500.0 | 88178.3 | 31778.3 | 156.9 |

Төвлөрүүлэх орлого 31778.3 мянган төгрөгөөр давсан нь барилгын техник хяналтын зардал тайлант ондоо орж байсан, иргэд, аж ахуй нэгжийн газрын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой кадастрын хэмжилт хийх ажил нэмэгдсэн шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны урсгал зардалд 445971.7 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 445971.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд цалин хөлсний зардлыг 15595.4, ажил олгогчоос төлөх НДШ-ийг 2509.4, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 1337.4, эд хогшил худалдан авах зардлыг 27.3, мянган төгрөгөөр тус тус хэмнэж 18530.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 583945.4 мянган төгрөг буюу 122.7 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардалд нэмэлт санхүүжилтээр 44283.1 мянган төгрөгийн зарцуулах эрх үүссэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 30406.6, дээд шатны төсвийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 102138.5 мянга, нийт 132545.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардал, НДШ-ийн зардалд 8810.5, сум, баг хорооны зааг тогтооход 30406.6, гадаад томилолтын зардалд 16336.6, сэлбэг хэрэгсэлд 1305.0, сургалтын зардалд

4009.1, плотерын хор 4000.0, хяналтын зөвлөх зардалд 400.0, нийт 65267.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 67276,8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 22 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 16 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|-----|---------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 3 | 4479.5 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 707.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 1 | 7355.0 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 6 | 12541.5 | |

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Няравын бараа материалын тайлангаас түүвэрлэж үзэхэд нягтлан бодогч нярвын шатахууны тайланг гаргасан, шатахууны тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын дагуу батлагдсан маягтын дагуу тайлагнаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн зөрчлийг таслан зогсоох, дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Тэтгэмж авах эрх үүсээгүй ажилтны ажлаас халагдсан тэтгэмж 521.2 мянган төгрөгийг олгосон, мөн дээрх тэтгэмжийг цалингийн зардлаас зарцуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1 дэх заалттай, төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалттай бүрэн нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын хэмжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Шатахууны зардлаас 185884.5 төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай бүрэн нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, үнэлгээ, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.11. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад "Итгэл" үзүүлсэн учир зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зардлаас 2074.1 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 26.2 дахь "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузл сууриар бүртгэж, тайлагнана." гэсэн заалттай бүрэн нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх, холбогдох дүрэм журам зөрчигдөх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 308 дугаар тушаалын холбогдох заалт, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Аймгийн төв дотор суудлын автомашин унах эрхгүй албан тушаалтан автомашин хэрэглэн нийт 1100.4 мянган төгрөгийг зарцуулсан ЗГ-ийн 2015 оны 05 дугаар сарын

11-ний өдрийн тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.нь санхүүгийн тайлангийн аудитын хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх, батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

ЗГ-ийн 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр 1305000 төгрөгийг сэлбэг хэрэгслийн зардалд зарцуулсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 86 тоот тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам" -ын 7.1 дэх заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 86 тоот тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>41,151,217.56</u> | <u>48,294,398.56</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 41,151,217.56 | 48,294,398.56 |
| 351 | Түүхий эд материал | 4,510,760.00 | 8,093,920.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,510,760.00 | 8,093,920.00 |
| 354 | Хангамжийн материал | 36,640,457.56 | 40,200,478.56 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,655,077.61 | 14,090,066.61 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,880,323.95 | 24,222,923.95 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,747,000.00 | 212,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,358,056.00 | 1,675,488.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>523,673,817.07</u> | <u>513,274,532.15</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 523,673,817.07 | 513,274,532.15 |
| 392 | Биет хөрөнгө | 503,349,816.94 | 493,186,532.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 409,423,075.72 | 409,423,075.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -14,503,926.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 90,491,750.00 | 90,491,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -72,180,281.25 | -83,291,750.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 307,178,701.17 | 317,034,314.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -244,208,406.62 | -239,851,527.86 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,493,272.41 | 35,264,872.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -18,848,294.49 | -21,380,276.18 |
| 393 | Биет бус хөрөнгө | 20,324,000.13 | 20,088,000.15 |
| 39301 | Програм хангамж | 3,210,000.00 | 3,210,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,355,999.87 | -2,591,999.85 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,470,000.00 | 19,470,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>564,825,034.63</u> | <u>561,568,930.71</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>564,825,034.63</u> | <u>561,568,930.71</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 564,825,034.63 | 561,568,930.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 427,169,483.31 | 427,169,483.31 |
| 51101 | Өмч: - төрийн | 427,169,483.31 | 427,169,483.31 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 39,851,576.85 | 36,750,260.83 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 39,851,576.85 | 40,006,364.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -3,256,103.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 97,803,974.47 | 97,649,186.57 |

| | | | |
|---|--|-----------------------|-----------------------|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 564,825,034.63 | 561,568,930.71 |
|---|--|-----------------------|-----------------------|

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 479,945,854.00 | 659,307,670.29 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 36,724,086.00 | 42,635,353.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 36,724,086.00 | 42,635,353.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,724,086.00 | 42,635,353.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,797,506.00 | 20,901,453.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,926,580.00 | 21,733,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 64,616,368.00 | 170,700,617.29 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,605,400.00 | 445,971,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 55,707,728.00 | 132,545,117.29 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,707,728.00 | 132,545,117.29 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 28,850,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 28,850,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 8,908,640.00 | 9,305,500.00 |
| 133003 | Хөрөнгийн | 8,908,640.00 | 9,305,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 517,628,663.39 | 662,563,774.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 517,628,663.39 | 662,563,774.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 451,823,473.39 | 536,291,374.92 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 265,727,734.00 | 322,208,461.00 |
| 210101 | Үндсэн цалин | 210,989,273.00 | 254,853,754.00 |
| 210102 | Нэмэгдэл | 33,908,300.00 | 51,053,363.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,416,817.00 | 9,441,097.00 |
| 210104 | Урамшуулал | 500,000.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,913,344.00 | 6,860,247.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,872,300.00 | 39,692,970.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,784,807.00 | 29,011,585.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,091,393.00 | 2,837,145.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,132,300.00 | 1,571,336.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 533,100.00 | 843,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,330,700.00 | 5,429,304.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,280,094.00 | 27,700,923.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,193,724.00 | 1,693,853.00 |

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын «Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|------------------------------|-----------------------------|
| 210302 | Түлш, халаалт | 25,382,920.00 | 25,238,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 703,450.00 | 768,670.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,198,906.00 | 16,096,541.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,330,150.00 | 10,139,661.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,805,800.00 | 4,805,820.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 403,486.00 | 513,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 912,340.00 | 637,860.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,747,130.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 459,400.00 | 305,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 459,400.00 | 305,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 903,830.00 | 784,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 903,830.00 | 784,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,380,600.00 | 2,224,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,380,600.00 | 2,224,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 236,400.00 | 206,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,400.00 | 57,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 142,000.00 | 148,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,764,209.39 | 127,072,779.92 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,450,894.00 | 76,271,895.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 59,313,315.39 | 50,800,884.92 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 65,805,190.00 | 126,272,399.29 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,130,448.00 | 19,564,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 17,329,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,130,448.00 | 2,234,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,162,144.00 | 18,165,326.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,642,288.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 519,856.00 | 18,165,326.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 364,777.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 364,777.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 57,512,598.00 | 88,178,296.29 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 57,512,598.00 | 88,178,296.29 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>-37,682,809.39</u> | <u>-3,256,103.92</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 109,250.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 109,250.00 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -109,250.00 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-37,792,059.39</u> | <u>-3,256,103.92</u> |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 466,314,105.00 | 628,268,270.29 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 27,797,506.00 | 20,901,453.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,797,506.00 | 20,901,453.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 27,797,506.00 | 20,901,453.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,797,506.00 | 20,901,453.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 438,516,599.00 | 607,366,817.29 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,605,400.00 | 445,971,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 55,707,728.00 | 132,545,117.29 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,707,728.00 | 132,545,117.29 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 28,850,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 28,850,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 4,203,471.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,203,471.00 | 00.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 456,944,605.00 | 607,296,670.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 456,944,605.00 | 607,296,670.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 386,935,944.00 | 481,024,271.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 265,727,734.00 | 322,022,661.00 |
| 210101 | Үндсэн цалин | 210,989,273.00 | 254,853,754.00 |
| 210102 | Нэмэгдэл | 33,908,300.00 | 51,053,363.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,416,817.00 | 9,441,097.00 |
| 210104 | Урамшуулал | 500,000.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,913,344.00 | 6,674,447.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,872,300.00 | 39,692,970.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,784,807.00 | 29,011,585.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,091,393.00 | 2,837,145.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,132,300.00 | 1,571,336.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 533,100.00 | 843,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,330,700.00 | 5,429,304.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,280,094.00 | 27,700,923.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,193,724.00 | 1,693,853.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,382,920.00 | 25,238,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 703,450.00 | 768,670.00 |

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын «Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,299,336.00 | 7,824,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 645,500.00 | 1,145,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,805,800.00 | 4,805,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 488,536.00 | 513,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,359,500.00 | 1,359,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 396,000.00 | 396,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,000.00 | 396,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 901,600.00 | 784,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 901,600.00 | 784,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,380,600.00 | 2,375,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,380,600.00 | 2,375,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 236,000.00 | 206,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,000.00 | 57,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 142,000.00 | 148,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,842,280.00 | 80,022,117.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,842,280.00 | 80,022,117.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 70,008,661.00 | 126,272,399.29 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,333,919.00 | 19,564,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4,203,471.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 17,329,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,130,448.00 | 2,234,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,162,144.00 | 18,165,326.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,642,288.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 519,856.00 | 18,165,326.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 364,777.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 364,777.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 57,512,598.00 | 88,178,296.29 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 57,512,598.00 | 88,178,296.29 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 9,369,500.00 | 20,971,600.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 9,369,500.00 | 20,971,600.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 9,369,500.00 | 20,971,600.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 9,369,500.00 | 20,971,600.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 9,369,500.00 | 17,200,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 3,771,600.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -9,369,500.00 | -20,971,600.00 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 427,169,483.31 | 97,803,974.47 | 39,851,576.85 | 00.00 | 564,825,034.63 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 427,169,483.31 | 97,803,974.47 | 39,851,576.85 | 00.00 | 564,825,034.63 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 154,787.90 | 00.00 | 154,787.90 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 427,169,483.31 | 97,803,974.47 | 40,006,364.75 | 00.00 | 564,979,822.53 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -154,787.90 | 00.00 | 00.00 | -154,787.90 |

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын «Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | |
|-----|---|-----------------------|----------------------|----------------------|--------------|----------------|
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -3,256,103.92 | 00.00 | -3,256,103.92 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 427,169,483.31 | 97,649,186.57 | 36,750,260.83 | 00.00 | 561,568,930.71 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 475,821,700.00 | 468,600,312.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 475,821,700.00 | 468,600,312.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 456,252,600.00 | 432,955,997.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 337,618,100.00 | 322,022,661.00 |
| 210101 | Үндсэн цалин | 255,152,000.00 | 254,853,754.00 |
| 210102 | Нэмэгдэл | 62,999,200.00 | 51,053,363.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,158,900.00 | 9,441,097.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,308,000.00 | 6,674,447.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,202,400.00 | 39,692,970.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,697,600.00 | 29,011,585.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,376,200.00 | 2,837,145.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,700,900.00 | 1,571,336.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 675,300.00 | 843,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,752,400.00 | 5,429,304.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,038,400.00 | 27,700,923.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,500,000.00 | 1,693,853.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,638,400.00 | 25,238,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 900,000.00 | 768,670.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,824,000.00 | 7,824,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,145,500.00 | 1,145,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,805,800.00 | 4,805,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 513,200.00 | 513,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,359,500.00 | 1,359,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 396,000.00 | 396,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,000.00 | 396,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 811,600.00 | 784,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 811,600.00 | 784,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,380,600.00 | 2,375,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,380,600.00 | 2,375,200.00 |

| | | | |
|---------------|---|----------------|---------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 242,500.00 | 206,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,000.00 | 57,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 148,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35739000.00 | 31953843.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,739,000.00 | 31,953,843.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19569100.00 | 19564000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 19,569,100.00 | 19,564,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,329,100.00 | 17,329,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,240,000.00 | 2,234,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 8,592,738.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 8,592,738.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 8,592,738.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 475,010,100.00 | 495,723,153.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 445,971,700.00 | 445,971,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 445,971,700.00 | 445,971,700.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 29,038,400.00 | 28,850,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 29,038,400.00 | 28,850,000.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 00.00 | 20,901,453.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 20,901,453.00 |